| 210104 | Урамшуулал | 612492700.00 | 573160218.14 | 502718400.00 | 524470854.47 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 204128300.00 | 204128300.00 | 204128300.00 | 204128300.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1196912700.00 | 1084503339.84 | 1148465700.00 | 1122884401.48 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 840431900.00 | 750584467.96 | 807930600.00 | 791992744.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 89120000.00 | 83683652.72 | 85133700.00 | 83537383.56 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 71296400.00 | 66546859.01 | 68107100.00 | 67158543.73 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 17823800.00 | 17279027.76 | 17026600.00 | 16285190.11 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 178240600.00 | 166409332.39 | 170267700.00 | 163910539.75 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 1684569700.00 | 1656664797.49 | 1803548400.00 | 1786327088.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 124602000.00 | 79766694.01 | 113102000.00 | 88218553.99 |
| 210302 | Түлш, халаалт | 1427269000.00 | 1490273092.48 | 1467745900.00 | 1494431234.61 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 132698700.00 | 86625011.00 | 124623700.00 | 107825500.00 |
| 210304 | Байрны түрээс | | | 98076800.00 | 95851800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 305073400.00 | 273712237.20 | 289883000.00 | 287641407.40 |
| 210401 | Бичиг хэрэг | 98182900.00 | 91369955.00 | 59784700.00 | 51536586.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 31907800.00 | 25125710.00 | 46031200.00 | 45171120.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 24956500.00 | 22263159.20 | 24787300.00 | 22519121.40 |
| 210404 | Ном, хэвлэл | 41882600.00 | 38249200.00 | 25004800.00 | 17176220.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1827000.00 | 1870100.00 | 134275000.00 | 151238360.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 106316600.00 | 94834113.00 | | |
| **2105** | **Нормативт зардал** | 597155900.00 | 375732219.00 | 409627200.00 | 336804919.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 36896700.00 | 26853360.00 | 29998200.00 | 29107867.00 |
| 210502 | Хоол, хүнс | 475117000.00 | 272381074.00 | 307303400.00 | 235390642.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 85142200.00 | 76497785.00 | 72325600.00 | 72306410.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 37600900.00 | 16599500.00 | 45825000.00 | 45820750.00 |
| 210604 | Урсгал засвар | 37600900.00 | 16599500.00 | 45825000.00 | 45820750.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 28151500.00 | 252000.00 | 30105500.00 | 12441350.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 28151500.00 | 252000.00 | 30105500.00 | 12441350.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 124591400.00 | 74330791.00 | 35826100.00 | 31483158.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 93899800.00 | 44335300.00 | 13759900.00 | 13750558.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 763600.00 | 214000.00 | 20938200.00 | 16604600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 469100.00 | 469100.00 | 469100.00 | 469100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 227700.00 | 226736.00 | 227700.00 | 227700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 73800.00 | 73800.00 | 73800.00 | 73800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 29003400.00 | 28930787.00 | 203400.00 | 203400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 138300.00 | 81068.00 | 138300.00 | 138300.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 15700.00 | | 15700.00 | 15700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 333414900.00 | 302348696.00 | 361021800.00 | 371181053.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 90034200.00 | 75934200.00 | 136657700.00 | 154657700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 243380700.00 | 226414496.00 | 224364100.00 | 216523353.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 182032900.00 | 122442290.00 | 264395000.00 | 248789670.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 182032900.00 | 122442290.00 | 264395000.00 | 248789670.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 177032900.0 | 119926290.0 | 232060700.00 | 216457370.00 |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | | | 22334300.00 | 22334300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5000000.0 | 2516000.0 | 10000000.00 | 9998000.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **238478900.0** | **199095450.0** | **456147900.0** | **445903446.0** |
| **2200** | Дотоод эх үүсвэрээр | 238478900.0 | 199095450.0 | 456147900.0 | 445903446.0 |
| 223001 | Бусад хөрөнгө | 238478900.0 | 199095450.0 | 456147900.00 | 445903446.00 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | 350000000.00 | 243250000.00 | 300000000.00 | 206975850.00 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 350000000.0 | 243250000.0 | 300000000.00 | 206975850.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 13975195800.00 | 12637461395.06 | 13649349000.00 | 13669099033.85 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 10683208300.00 | 9613031665.23 | 10159024400.00 | 9967195958.85 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 10683208300.0 | 9613031665.23 | 10159024400.00 | 9967195958.85 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2563347500.00 | 2675886615.66 | 2853105100.00 | 3109072989.00 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 2465868600.0 | 2578482603.66 | 2626536700.00 | 2882504637.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 97478900.0 | 97404012.0 | 226568400.00 | 226568352.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 728640000.00 | 348543114.17 | 637219500.00 | 366261734.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 532675600.0 | 348543114.2 | 281122500.00 | 366261734.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 195964400.0 | | 356097000.00 | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **0.0** | **19552892.24** | 0.00 | 79484478.23 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **0.0** | **79484478.23** | 0.00 | 188407758.23 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **0.0** | **0.0** | 29.00 | 0.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 17.00 | 17.00 | 17.00 | 17.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 17.0 | 17.0 | 17.00 | 17.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 687.00 | 687.00 | 687.00 | 618.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 24.0 | 24.0 | 24.00 | 23.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 449.0 | 449.0 | 449.00 | 397.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 193.0 | 193.0 | 193.00 | 177.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 21.0 | 21.0 | 21.00 | 21.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **382819854.82** | **678106522.56** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **371480854.82** | **538400668.06** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 245006363.00 | 189599665.28 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1167975.00 | 2400895.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1167975.00 | 2400895.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 498125.00 | 0.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 498,125.00 | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 0.00 | 2150000.00 |
| 210302 | Түлш, халаалт | | 1000000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 1150000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16845574.00 | 24735927.28 |
| 210401 | Бичиг хэрэг | 1067600.00 | 5019627.28 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,300,000.00 | 6,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3114234.00 | 4327000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 2584100.00 | 5413300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8779640.00 | 3976000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 600000.00 | 1100000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 600,000.00 | 1,100,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 23617900.00 | 10364600.00 |
| 210604 | Урсгал засвар | 23617900.00 | 10364600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5031449.00 | 8937175.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5031449.00 | 8937175.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 197245340.00 | 139911068.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 194,829,700.00 | 93,820,366.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2415640.00 | 46090702.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 82227044.00 | 264612094.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 82227044.00 | 264612094.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 76164324.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 81277044.00 | 180488622.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 950,000.00 | 7,959,148.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **44247447.82** | **84188908.78** |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 44247447.82 | 84188908.78 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **11339000.00** | **139705854.50** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 11339000.00 | 139705854.50 |
| 223001 | Бусад хөрөнгө | | 109485397.00 |
| 225001 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 11339000.00 | 30220457.50 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 382819854.82 | 678106522.56 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 382819854.82 | 678106522.56 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 21793440.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 365,948,954.82 | 562,687,005.74 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 16870900.00 | 93626076.82 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улиастай сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Ч.Наранбат-т танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Г.Баасанжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Дагвасүрэн, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Улиастай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 1/135 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ОРЧИН БА ДОТООД ХЯНАЛТ

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж, мэргэшсэн албан хаагчдаар төрийн албыг бэхжүүлэн, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, тэгш хүртээмжтэй хүргэж, сумын хөгжлийн төлөө ажиллахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сумын засаг даргын дэргэд дотоод хяналтын нэгжийг байгуулсан байна. Энэхүү хяналтын нэгж нь ТШЗ-ын үйл ажиллагаанд хяналтыг хангалттай хэмжээнд хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улиастай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр мөнгөн хөрөнгөөр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн 17,004.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 255.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75% буюу 191.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 439.7 | 193.7 | (246.0) |
| Авлага | 990.0 | 848.9 | (141.1) |
| Бараа материал | 1,349.8 | 1,494.1 | 144.3 |
| Үндсэн хөрөнгө | 15,066.5 | 15,041.8 | (24.7) |
| **Нийт хөрөнгө** | **17,846.0** | **17,578.5** | **(267.5)** |
| Өр төлбөр | 43.7 | 100.1 | 56.4 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 17,802.3 | 17,478.4 | (323.9) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **17,846.0** | **17,578.5** | **(267.5)** |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 246.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл өмнөх оноос 56 хувиар буурсан байна.

Авлага дансны үлдэгдэл 141.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд байгууллага болон хувь хүмүүсээс авах авлага буурсан байна. Байгууллагуудын авлага дансны өөрчлөлтийг дараах байдлаар харуулав.

/төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| ЗДТГ | - | - |
| ИТХ | - | - |
| СХсан | 978,224,421.45 | 836,803,203.45 |
| ОНХСан | - | |
| төрийн сан | - | |
| Дэвшил сургууль | | |
| Жавхлант цогцолбор сургууль | 2,713,904.79 | 1,053,096.10 |
| ЕБ-ийн лаборатори ЧЭСургууль | 1,584,514.84 | 918,561.30 |
| Улиастай 3-р сургууль | 3,199,899.00 | 9,786,839.00 |
| Улиастай 4-р сургууль | - | |
| Улиастай 1-р цэцэрлэг | | |
| Улиастай 2-р цэцэрлэг | - | |
| Улиастай 3-р цэцэрлэг | - | |
| Улиастай 4-р цэцэрлэг | | 47,493.54 |
| Улиастай 5-р цэцэрлэг | | |
| Улиастай 6-р цэцэрлэг | 4,000,463.00 | |
| Улиастай 7-р цэцэрлэг | 70,000.00 | 70,000.00 |
| Улиастай 8-р цэцэрлэг | 184,800.00 | |
| Улиастай 9-р цэцэрлэг | - | 192,340.67 |
| **ДҮН** | **989,978,003.08** | **848,871,534.06** |

Бараа материал дансны үлдэгдэл 144.3 сая төгрөгөөр өссөн нь төсөвт байгууллагуудын эм боох болон бусад хангамжийн материалын худалдан авалт их байсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 24.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардалтай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 56.4 сая төгрөг болж нь өссөн нь дараах байгууллагуудаас шалтгаалж байна.

/төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| ЗДТГ | - | |
| ИТХ | - | - |
| СХсан | - | |
| ОНХСан | - | |
| төрийн сан | - | |
| Дэвшил сургууль | 6,153,977.74 | |
| Жавхлант цогцолбор сургууль | - | |
| ЕБ-ийн лаборатори ЧЭСургууль | 15,653,581.52 | 73,055,829.52 |
| Улиастай 3-р сургууль | 21,700,074.00 | 14,003,681.39 |
| Улиастай 4-р сургууль | - | |
| Улиастай 1-р цэцэрлэг | - | 11,565,000.00 |
| Улиастай 2-р цэцэрлэг | - | |
| Улиастай 3-р цэцэрлэг | - | |
| Улиастай 4-р цэцэрлэг | - | 1,447,695.00 |
| Улиастай 5-р цэцэрлэг | - | 47,333.54 |
| Улиастай 6-р цэцэрлэг | | |
| Улиастай 7-р цэцэрлэг | 184,800.00 | |
| Улиастай 8-р цэцэрлэг | - | |
| Улиастай 9-р цэцэрлэг | - | |
| **ДҮН** | **43,692,433.26** | **100,119,539.45** |

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 323.9 сая төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүн болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөс шалтгаалж байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг анх батлахдаа 13,649.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 13,649.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 12,893.2 сая төгрөгийг урсгал зардалд, 456.1 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 300.0 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 10,159.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 2,626.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 226.6 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 281.1 сая төгрөгийг үндсэн

болон туслах үйл ажиллагааны орлогоос, 356.1 сая төгрөгийг урд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 9,967.2 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 2,882.5 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 226.6 сая төгрөг, 366.2 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, нийт 13,442.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нь 104.9 сая төгрөг дутуу байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 300.0 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 97.0 сая төгрөг дутуу зээлийн эргэн төлөлт хийсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 13,337.6 сая төгрөг буюу 0.8 хувьтай байгаа нь төсөвт санхүүжилт дутуу олгогдсонтой холбоотой байна.

Урсгал санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 85.9 сая төгрөгийг сумын төсөвт, 264.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 678.1 сая төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний зардалд 189.6 сая төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 76.2 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 7.9 сая төгрөг, хөдөө ОНТША албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 180.5 сая төгрөг, хөрөнгийн зардалд 139.7 сая төгрөгийг тус тус зарцуулж 84.2 сая төгрөгийг орон нутгийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд онцлон үзэх эрсдэлтэй асуудал тусгагдаагүй байна.

## 3.8 Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Аудитын хүрээнд төсвийн төвлөрүүлэн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлттэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд оруулбал зохих 155 мэдээллээс 110 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 41 мэдээллийг хугацаа хоцроосон, 4 мэдээллийг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Улиастай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд бусад мэдээлэлтэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй бөгөөд өмнөх санхүүгийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах эрсдэлтэй асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

ТТЗ-ийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн аудитаар нийт 25.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс зардлыг зориулалт бус зарцуулж тэмцээний хувцас 1.5 сая төгрөгөөр худалдан авсан, зардал хооронд гүйлгэн зарцуулсан 24.0 сая төгрөгийн зөрчил байна.

### 4.2.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулгын алдаа илрээгүй болно.

### 4.2 .2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй байна.

### 4.2.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй байна.

### 4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1 Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал**

*<u>Илрүүлэлт:</u> Төсвийн шууд захирагчдын аудитаар илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд, шууд захирагчдын төрийн сангаар хийгдэж буй ажил гүйлгээнд хяналт тавиагүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүйтэй холбоотой зөрчил байна. Тухайлбал: Зардлыг*

*зориулалт бус зарцуулж сургуулийн ажилчдад тэмцээний хувцас худалдан авсан, зардал хооронд гүйлгэн зарцуулсан зэрэг зөрчлүүд байна.*

*Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 3 дугаар зүйлийн 3.7.6. хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэсэн заалтууд, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.*

*Өгсөн зөвлөмж:*

Төсөв захирагчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, арга зүйгээр хангаж ажиллах, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Төсвийн шууд захирагч болон төвлөрүүлэн захирагчийн алдаа зөрчлийн нэгтгэлийг доорх хүснэгтээр нэгтгэв.

/сая төгрөгөөр/

| № | Шалгагдагч байгууллагын нэр | Залруулга | | Нийт алдаа, зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Улиастай 1 сумын цэцэрлэг | 3 | 33.15 | 1 | 0.34 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0.34 |
| 2 | Улиастай сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг | 0 | 0 | 2 | 4.98 | 0 | 0.00 | 0 | 0.00 | 2 | 4.98 |
| 3 | Улиастай сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэг | 0 | 0 | 1 | 2.69 | 0 | 0.00 | 0 | 0.00 | 1 | 2.69 |
| 4 | Улиастай сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг | 0 | 0 | 2 | 2.53 | 0 | 0.00 | 0 | 0.00 | 2 | 2.53 |
| 5 | Улиастай сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэг | 0 | 0 | 3 | 11.93 | 1 | 0.94 | 0 | 0.00 | 2 | 10.98 |
| 6 | Улиастай сумын Хүүхдийн 8 дугаар цэцэрлэг | 0 | 0 | 1 | 3.73 | 0 | 0.00 | 1 | 3.73 | 0 | 0.00 |
| 7 | Улиастай сумын 9-р цэцэрлэг | 0 | 0 | 1 | 2.98 | 0 | 0.00 | 0 | 0.00 | 1 | 2.98 |
| 8 | Улиастай сумын ЗДТГ | 1 | 0.45 | 4 | 114.13 | 0 | 0.00 | 1 | 89.84 | 3 | 24.29 |
| 9 | Улиастай сумын Жавхлант цогцолбор сургууль | 0 | 0 | 2 | 10.29 | 0 | 0.00 | 2 | 10.29 | 0 | 0.00 |
| 10 | Улиастай сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль | 4 | 37.01 | 3 | 10.68 | 0 | 0.00 | 1 | 5.20 | 2 | 5.48 |
| 11 | Дэвшил сургууль | 2 | 56.00 | 3 | 11.32 | 1 | 2.25 | 0 | 0.00 | 2 | 9.08 |
| 12 | Ерөнхий боловсролын лаборатори Чандмань-Эрдэнэ сургууль | 0 | 0 | 2 | 5.39 | 0 | 0.00 | 1 | 3.74 | 1 | 1.65 |
| 13 | Ерөнхий боловсролын 3-р сургууль | 0 | 0 | 2 | 10.29 | 0 | 0.00 | 2 | 10.29 | 0 | 0.00 |
| 14 | Завхан аймгийн Улиастай сумын ОНХС | 0 | 0 | 1 | 14.00 | 0 | 0.00 | 1 | 14.00 | 0 | 0.00 |
| 15 | Улиастай сумын СХС | 0 | 0 | 0 | 0.00 | 0 | 0.00 | 0 | 0.00 | 0 | 0.00 |
| 16 | Улиастай сумын ИТХ | 0 | 0 | 0 | 0.00 | 0 | 0.00 | 0 | 0.00 | 0 | 0.00 |
| 17 | Улиастай сумын Засаг дарга | 0 | 0 | 1 | 25.49 | 0 | 0.00 | 0 | 0.00 | 1 | 25.49 |
| **Дүн** | | **10** | **126.60** | **29** | **230.75** | **2** | **3.19** | **9** | **137.07** | **18** | **90.49** |

**БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:**

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА 2022.03.24

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ДАГВАСҮРЭН 2022.03.24

АХЛАХ АУДИТОР Б.ЖАЛБАА 2022.03.24

**БЭЛТГЭСЭН:**

АУДИТОР Г.БААСАНЖАРГАЛ 2022.03.24